

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 12-ны 187 тоот
тушаалын 02 дугаар хавсралт*



ИНД - 39

Иргэний Нисэхийн Дүрэм

Нислэгт тэнцэх чадварын удирдамж

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-39 нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- үйл ажиллагаа эрхлэгчийн НТЧ-ын удирдамжийн хэрэгжүүлэлт;
- НТЧ-ын удирдамжид заасан шаардлагыг хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангах зөвшөөрөл.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-39-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-39, түүний нэмэлт өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт	2001 оны 10 сарын 01
Нэмэлт өөрчлөлт 1	2007 оны 05 сарын 04
Нэмэлт өөрчлөлт 2	2008 оны 02 сарын 29
Нэмэлт өөрчлөлт 3	2009 оны 09 сарын 16
Нэмэлт өөрчлөлт 4	2010 оны 05 сарын 07
Нэмэлт өөрчлөлт 5	2015 оны 09 сарын 01
Нэмэлт өөрчлөлт 6 (Шинэчлэлт)	2019 оны 06 сарын 12

Тэмдэглэл: ИНД-39-ийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 39-ийн 2007 оны 03 сарын 01-ний А.1-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	1
39.1. Зорилго.....	1
39.3. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх.....	1
В Бүлэг - НТЧ-ын удирдамж.....	1
39.51. Хэрэгжүүлэлт	1
39.53. Хэрэгжүүлэлтийн өөр хэлбэр.....	1
39.55. Хойшлуулсан хэрэгжүүлэлт	2
39.57. НТЧ-ын хадгалалтын бусад зааварчилгаатай зөрчилдөх	2

А Бүлэг - Ерөнхий зүйл

39.1. Зорилго

Энэ Дүрэм нь дараах шаардлагыг тогтооно:

- (1) үйл ажиллагаа эрхлэгчийн НТЧ-ын Удирдамжийн хэрэгжүүлэлт;
- (2) НТЧ-ын Удирдамжид заасан шаардлагыг хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангах зөвшөөрөл.

39.3. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх

Дарга энэ дүрмийн 39.51-ийн шаардлагаас чөлөөлөхгүй.

В Бүлэг - НТЧ-ын удирдамж

39.51. Хэрэгжүүлэлт

(a) Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөхгүй:

- (1) Хуульд заасны дагуу Даргын гаргасан, хамааралтай НТЧ-ын Удирдамж бүрийг хангасан байх;
- (2) агаарын хөлгийн хувьд:
 - (i) тухайн агаарын хөлгийг зохион бүтээгч улсын гаргасан хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг хангасан байх;
 - (ii) тухайн агаарын хөлөгт ашиглагдаж байгаа нисэхийн бүтээгдэхүүнийг зохион бүтээгч улсын гаргасан хамааралтай НТЧ-ын удирдамж бүрийг хангасан байх; эсхүл
- (3) энэ хэсгийн (1) болон (2)-т заасны дагуу, тухайн агаарын хөлөгт хамааралтай НТЧ-ын Удирдамжийг 39.53-ын дагуу Даргын зөвшөөрсөн хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангасан байх.

(b) Хэрэв Даргаас агаарын хөлгийн Яаралтай НТЧ-ын Удирдамжийн мэдэгдэл авсан этгээд нь тухайн агаарын хөлөгт Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшдэггүй бол, гэрчилгээ эзэмшигч биш болохоо Даргад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

39.53. Хэрэгжүүлэлтийн өөр хэлбэр

(a) Энэ дүрмийн 39.51(a)(1) болон (a)(2)-т шаардсаны дагуу НТЧ-ын Удирдамжийн шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн НТЧ-ын Удирдамжид заасан шаардлагыг хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангах зөвшөөрөл авах хүсэлтийг Даргад гаргаж болно.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу НТЧ-ын Удирдамжийг хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр хангах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь:

- (1) САА 24039/01 маягыг бөглөж;
- (2) зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(с) Хэрэв Дарга хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрийг хэрэглэснээр тухайн НТЧ-ын Удирдамжийн шаардлагыг хангасантай дүйцэх аюулгүй байдлын түвшнийг хангана гэж үзвэл, Дарга тухайн НТЧ-ын Удирдамжийн хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрийг үйл ажиллагаа эрхлэгчид зөвшөөрч болно.

39.55. Хойшлуулсан хэрэгжүүлэлт

Хэрэв НТЧ-ын Удирдамж нь агаарын хөлөг, эсхүл агаарын хөлөгт суурилуулсан нисэхийн бүтээгдэхүүнд дараалсан, цуврал үзлэг шалгалт хийхийг шаардсан бол агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь НТЧ-ын удирдамжаар тусгайлан хориглосноос бусад тохиолдолд, анхан шатны үзлэгээс бусад шаардлагатай үзлэг шалгалтыг НТЧ-ын Удирдамжид заасан үзлэг шалгалтын давтамжаас 10%-иас ихгүй хугацаагаар хойшлуулж, бусад хуваарьт техник үйлчилгээний үед гүйцэтгэхийг зөвшөөрч болно.

39.57. НТЧ-ын хадгалалтын бусад зааварчилгаатай зөрчилдөх

Хэрэв НТЧ-ын Удирдамжид заасан шаардлага нь НТЧ-ын хадгалалтын холбогдох бусад зааварчилгаатай зөрчилдөж байгаа бол, НТЧ-ын Удирдамжид заасан тухайн шаардлага нь давамгайлна.

--oOo--